



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2020 оны 10 сарын 20 өдөр

Дугаар 532

Улаанбаатар хот

С.Бат-Эрдэнийг ажилд томилох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9, 18 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 19 дүгээр зүйл, Хөдөлмөрийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 260 дугаар тогтоолоор баталсан “Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх журам”-ын 2.1, 2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2020 оны 1/6182 дугаар албан бичгээр ирүүлсэн санал, Авлигатай тэмцэх газрын 2020 оны 05/10680 дугаар албан бичгээр ирүүлсэн дүгнэлтийг тус тус харгалзан Сүхээгийн Бат-Эрдэнийг “Аялал жуулчлалын хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирлаар 2020 оны 10 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн томилсугай.

2. С.Бат-Эрдэнэтэй контрактын гэрээг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ